



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Очирбатын АМГАЛАНБААТАР

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон

Утас: 26-45-25, Факс: 32-70-16

E-mail: amgalanbaatar@parliament.mn

<http://www.parliament.mn>

1015.03.14 № 411х-03/2954
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Амьтны тухай хуулийн төслийг санаачлан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



О.АМГАЛАНБААТАР

• 2025000189



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Очирбатын АМГАЛАНБААТАР**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон

Утас: 26-45-25, Факс: 32-70-16

E-mail: amgalanbaatar@parliament.mn

<http://www.parliament.mn>

2024.12.03 № УИХ-03/6553
танай _____-ны № _____-т

**Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
тов тогтоолгох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Амьтны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсрууллаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү.

Хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, хуулийн төсөл, холбогдох судалгаануудыг хавсаргав.

Хавсралт: ~~26~~ хуудастай.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



О.АМГАЛАНБААТАР

2024000249

**БАТЛАВ.
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**

О.АМГАЛАНБААТАР

**АМЬТНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1Хууль зүйн шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 ... амьд явах эрхтэй ... гэж заасан.

Монгол Улсад 1986 оны байдлаар 30 гаруй мянган чоно 18 аймгийн нутаг дэвсгэрт тархсан гэж Шинжлэх ухааны академийн Биологийн хүрээлэнгийн эрдэмтдийн гаргасан судалгаанд дурджээ. Үүнээс хойш улсын хэмжээнд чонын талаар нарийвчлан судалсан судалгаа, мэдээлэл байхгүй байна.

Амьтны тухай хууль 2012 онд батлагдсанаар бүс нутгийн амьтны зүйлийн бүрдэл, тэдгээрийн тархац, нөөцийн судалгааг хийж зэрлэг амьтны мэдээллийн санг тогтмол шинэчилсний үндсэн дээр зэрлэг амьтныг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх ан агнуурын менежментийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн.

Түүнчлэн Амьтны тухай хуулиар чоно агнахад заавал зөвшөөрөл авч хураамж төлөхөөр зохицуулсан буюу зөвшөөрөл аваагүй чоно агнасан бол торгууль төлөхөөр хуульчилсан байна. Уг хуулийн зохицуулалт нь бодит амьдралд хэрэгжихэд хэд хэдэн асуудал үүсч байгаа буюу хөдөө амьдарч иргэд амь нас, мал сүрэгээ хамгаалахад эрсдэл үүсч байгаа талаар судалгаа харуулж байна.

1.2.Практик шаардлага

Амьтны тухай хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу иргэн зохих төлбөр төлж, сумын Засаг даргаас олгосон эрхийн бичгийн дагуу агнуурын ховор амьтнаас бусад амьтныг өөрийн ахуйн зориулалтаар агнаж, барьж болох бөгөөд тус эрхийн бичигт иргэний овог, нэр, агнах, барих агнуурын амьтны зүйл, тоо, агнах, барих хугацаа, газар, төлбөр, хураамжийн хэмжээг нарийвчлан заадаг. Тус хуулийн 28 дугаар зүйлийн 28.3.2-т заасны дагуу чоно агнах, барих зөвшөөрлийг тав хүртэл хоногийн хугацаатай олгодог байна.

Мөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3, 17 дугаар зүйлийн 17.1.2-д тус тус заасны дагуу Засгийн газрын 2023 оны "Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлах тухай" 260 дугаар тогтоолыг үндэслэн тухайн амьтны экологи-эдийн засгийн үнэлгээний 20 хувиар буюу 226,000 төгрөгөөр, зөвшөөрлийн хураамжийг 2 хувиар буюу 22,600 төгрөгөөр тус тус тооцож нэг чоно агнах зөвшөөрөл 248,600 төгрөгийн үнэлгээтэй байна.

Улсын Их Хурлын гишүүн миний бие сонгогдсон аймаг, сум, багт ажиллах үед малчид иргэдийн хамгийн ихээр тавьж байсан саналын нэг нь чоно агнахтай холбоотой асуудал байв. Иргэд, малчид чоно агнах, түүнтэй холбоотой төлбөр, зөвшөөрлийн талаар дараах агуулга бүхий тайлбар, мэдээллийг өгсөн болно.

Нэгдүгээрт, ан агнах зөвшөөрлийн бичиг нь тав хүртэлх хоногийн хугацаатай байдаг бөгөөд хэрэв тухайн хугацаанд ан хийж чадаагүй бол дахин зөвшөөрөл авах шаардлага үүсдэг тул төлбөр төлж зөвшөөрөл авах сонирхолгүй байдаг. Мөн чоно агнах зөвшөөрлийн төлбөр өндөр тул зөвшөөрөл авах боломж малчдын хувьд хязгаарлагдмал байна.

Хоёрдугаарт, хуульд заасны дагуу ан агнах зөвшөөрөл авахад шаардлагатай олон баримт бичиг бүрдүүлэх нь малчин иргэдийн хувьд хүндрэлтэй байдаг бөгөөд тухайлбал, ангийн буу өмчлөх, эзэмших зөвшөөрөл авахад хүндрэлтэй байдаг.

Гуравдугаарт, малчин иргэд зөвшөөрөлгүй чоно агнавал торгууль өндөр, чоно хүн рүү болон мал руу дайрвал заавал зөвшөөрөл авч байж буудахгүй бол зөвшөөрөлгүй ан агнасан хэргээр торгууль оногдуулах заалттай учир иргэд чоно агнахгүй байгаагаас болж чоно элбэгшиж, хүнээс айхгүй түвшинд хүрсэн. Мөн чоно ихэссэнээс бодын төл авч чадахаа байхад хүрч байгаа нь малчдын амжиргаанд нөлөөлж байгаа тул үүнийг амьдралд тохиромжтой байдлаар зохицуулж өгөхийг хүсч байна.

Хоёр.Хуулийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ
Энэхүү хуулийн төсөл нь 2 зүйлтэй бөгөөд Амьтны тухай хуулийн 25 дугаар зүйлд нэмэлт оруулахаар зохицуулсан.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал:

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын үндсэн хуульд заасан амьд явах эрх, малчид өөрийгөө болон мал сүргээ чононоос хамгаалах эрх хангагдах ач холбогдолтой.

Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн талаарх санал:

Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц болон бусад хууль тогтоомжид нийцсэн бөгөөд хуулийн төслийг дагаж бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй болно.

---oOo---

ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Амьтны тухай хуульд нэмэлт
оруулах тухай

Монгол Улсад 1986 оны байдлаар 30 гаруй мянган чоно 18 аймгийн нутаг дэвсгэрт тархсан гэж Шинжлэх ухааны академийн Биологийн хүрээлэнгийн эрдэмтдийн гаргасан судалгаанд дурджээ. Үүнээс хойш улсын хэмжээнд чонын талаар нарийвчлан судалсан судалгаа, мэдээлэл байхгүй байна.

Амьтны тухай хууль 2012 онд батлагдсанаар бүс нутгийн амьтны зүйлийн бүрдэл, тэдгээрийн тархац, нөөцийн судалгааг хийж зэрлэг амьтны мэдээллийн санг тогтмол шинэчилсний үндсэн дээр зэрлэг амьтныг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх ан агнуурын менежментийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн.

Амьтны тухай хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу иргэн зохих төлбөр төлж, сумын Засаг даргаас олгосон эрхийн бичгийн дагуу агнуурын ховор амьтнаас бусад амьтныг өөрийн ахуйн зориулалтаар агнаж, барьж болох бөгөөд тус эрхийн бичигт иргэний овог, нэр, агнах, барих агнуурын амьтны зүйл, тоо, агнах, барих хугацаа, газар, төлбөр, хураамжийн хэмжээг нарийвчлан заадаг. Тус хуулийн 28 дугаар зүйлийн 28.3.2-т заасны дагуу чоно агнах, барих зөвшөөрлийг тав хүртэл хоногийн хугацаатай олгодог байна.

Мөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3, 17 дугаар зүйлийн 17.1.2-д тус тус заасны дагуу Засгийн газрын 2023 оны “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлах тухай” 260 дугаар тогтоолыг үндэслэн тухайн амьтны экологи-эдийн засгийн үнэлгээний 20 хувиар буюу 226,000 төгрөгөөр, зөвшөөрлийн хураамжийг 2 хувиар буюу 22,600 төгрөгөөр тус тус тооцож нэг чоно агнах зөвшөөрөл 248,600 төгрөгийн үнэлгээтэй байна.¹

Улсын Их Хурлын гишүүн миний бие сонгогдсон аймаг, сум, багт ажиллах үед малчид иргэдийн хамгийн ихээр тавьж байсан саналын нэг нь чоно агнахтай холбоотой асуудал байв. Иргэд, малчид чоно агнах, түүнтэй холбоотой төлбөр, зөвшөөрлийн талаар дараах агуулга бүхий тайлбар, мэдээллийг өгсөн болно.

¹ Засгийн газрын 2011 оны “Үнэлгээ, төлбөр, хураамжийн хэмжээг шинэчлэн батлах тухай” 23 дугаар тогтоолын дагуу чоно агнах зөвшөөрлийн төлбөрийг тухайн амьтны экологи-эдийн засгийн үнэлгээний 20 хувиар буюу 102,000 төгрөгөөр, зөвшөөрлийн хураамжийг 2 хувиар буюу 10,200 төгрөгөөр тус тус тооцож нэг чоно агнах зөвшөөрөл 112,200 төгрөгийн үнэлгээтэй байсан.

- Нэгдүгээрт, ан агнах зөвшөөрлийн бичиг нь тав хүртэлх хоногийн хугацаатай байдаг бөгөөд хэрэв тухайн хугацаанд ан хийж чадаагүй бол дахин зөвшөөрөл авах шаардлага үүсдэг тул төлбөр төлж зөвшөөрөл авах сонирхолгүй байдаг. Мөн чоно агнах зөвшөөрлийн төлбөр өндөр тул зөвшөөрөл авах боломж малчдын хувьд хязгаарлагдмал байна.
- Хоёрдугаарт, хуульд заасны дагуу ан агнах зөвшөөрөл авахад шаардлагатай олон баримт бичиг бүрдүүлэх нь малчин иргэдийн хувьд хүндрэлтэй байдаг бөгөөд тухайлбал, ангийн буу өмчлөх, эзэмших зөвшөөрөл авахад хүндрэлтэй байдаг.
- Гуравдугаарт, малчин иргэд зөвшөөрөлгүй чоно агнавал торгууль өндөр, чоно хүн рүү болон мал руу дайрвал заавал зөвшөөрөл авч байж буудахгүй бол зөвшөөрөлгүй ан агнасан хэргээр торгууль оногдуулах заалттай учир иргэд чоно агнахгүй байгаагаас болж чоно элбэгшиж, хүнээс айхгүй түвшинд хүрсэн. Мөн чоно ихэссэнээс бодын төл авч чадахаа байхад хүрч байгаа нь малчдын амжиргаанд нөлөөлж байгаа тул үүнийг амьдралд тохиромжтой байдлаар зохицуулж өгөхийг хүсч байна.

Малчид өмнө нь чоно ихэссэн тохиолдолд нийлж чоно агнадаг байсан буюу чоно агнасан хүнийг нэг хониор шагнадаг байсан, одоо малчин иргэд зөвшөөрөлгүй чоно агнах боломжгүй, амь насаа, мал сүргээ чононоос хэрхэн хамгаалахаа мэдэхгүй байгаа талаар мэдээлэл өгсөн буюу бодит амьдралд уг хуулийн заалтууд нийцэхгүй байгааг илэрхийлж байна.

Чоно агнахад төлбөрөөс чөлөөлөх нөхцөл, түүний хэрэгжилтийн талаар хянан үзсэн бөгөөд дараах хуулийн зохицуулалтын хүрээнд чоно агнах төлбөрөөс чөлөөлөгдөх үндэслэл болдог байна. Үүнд:

- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3-т заасан “мал сүргийг хамгаалах болон тодорхой нутаг дэвсгэрт тоо толгойг нь сийрэгжүүлэх зорилгоор чоно агнах”;
- Амьтны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-д заасан “Байгалийн тэнцлийг хангах, хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, халдварт өвчний голомтыг эрүүлжүүлэх болон мал, гэрийн тэжээвэр амьтанд өвчин халдварлах, иргэн, хуулийн этгээдэд хохирол учруулахаас сэрэмжлэх зорилгоор зарим амьтны тоо толгойг зохицуулах арга хэмжээ авч болно” гэсэн хэсэг, заалтууд байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3-д заасан “мал сүргийг хамгаалах болон тодорхой нутаг дэвсгэрт тоо толгойг нь сийрэгжүүлэх..” нөхцөлийг тогтохдоо Амьтны тухай хуульд заасны дагуу тухайн амьтны тархац, байршил, нөөц, төрөл, зүйл, тоо толгой, сүргийн бүтэц, өөрчлөлтийг судлан тогтоож, агнуурын нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, өсгөн үржүүлэх арга хэмжээг цогц байдлаар тодорхойлж тухайн аймгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөнд тусгасан байх хуулийн зохицуулалттай.

Харин Амьтны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-д “Байгалийн тэнцлийг хангах, хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, халдварт өвчний голомтыг эрүүлжүүлэх болон мал, гэрийн тэжээвэр амьтанд өвчин халдварлах, иргэн, хуулийн этгээдэд хохирол учруулахаас сэрэмжлэх зорилгоор зарим амьтны тоо толгойг зохицуулах арга хэмжээ авч болно” гэж заасан бөгөөд өнгөрсөн хугацаанд аймгуудын мэргэжлийн байгууллагад чонотой холбоотой дээрх нөхцөл тогтоогдож бүртгэгдсэн тохиолдол байхгүй байна.

Зөвшөөрөлгүй чоно агнасан тохиолдолд Зөрчлийн тухай хууль болон Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн дагуу дараах хариуцлагыг хүлээлгэдэг. Үүнд:

- Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйлд заасны дагуу хугацаа дууссан гэрээ, зөвшөөрлөөр, эсхүл гэрээ, зөвшөөрөлгүйгээр амьтныг ашигласан, барьсан, агнасан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно;
- Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.4 дэх хэсэгт заасны дагуу амьтны аймагт учирсан хохирлыг тухайн амьтны экологи-эдийн засгийн үнэлгээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний нөхөн төлбөрийг төлүүлнэ.

Торгууль, нөхөн төлбөрийн хэмжээ: Засгийн газрын 2023 оны “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлах тухай” 260 дугаар тогтоолын хавсралтад заасны дагуу чонон экологи-эдийн засгийн үнэлгээг 1,130,000 сая төгрөгөөр тогтоосон байна. Зөвшөөрөлгүй чоно агнасан тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйлд заасны дагуу торгууль төлөхөөс гадна Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.4 дэх хэсэгт заасны дагуу 2,260,000 төгрөгийн нөхөн төлбөр төлдөг.

Зөвшөөрөлгүй чоно агнасан тохиолдолд хүлээлгэх торгууль, төлбөрийн хэмжээг хууль тогтоомжоор тодорхой зохицуулсан боловч амь нас, мал сүрэгээ хамгаалах шаардлага үүсч тухайн үедээ зөвшөөрөлгүй чоно агнасан ч торгууль, төлбөр төлөхөөр

зохицуулсан нь Монгол Улсын үндсэн хуульд заасан амьд явах эрх, өмчтэй байх эрхүүд зөрчигдөх хэмжээний зохицуулалт байгааг илтгэж байна. Түүнчлэн өргөн уудам нутаг дэвсгэрт нүүдлийн соёлтой амьдарч буй малчин иргэд чоно агнах нөхцөл үүсвэл зөвшөөрөл авах гэж материал бүрдүүлж байж агнахгүй бол торгууль төлөхөөр зохицуулсан нь бодит амьдралд нийцэх зохицуулалт биш байгааг илтгэж байна.

2024 оны 10 дугаар 30-ны өдөр Засгийн газраас санал авахаар хүргүүлсэн боловч, санал дүгнэлт ирээгүй болно.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

АМЬТНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Улсын Их Хурлын гишүүн миний бие сонгогдсон аймаг, сум, багт ажиллах үед малчид иргэдийн хамгийн ихээр тавьж байсан саналын нэг нь чоно агнахтай холбоотой асуудал байв. Иргэд, малчид чоно агнах, түүнтэй холбоотой төлбөр, зөвшөөрлийн талаар дараах агуулга бүхий тайлбар, мэдээллийг өгсөн болно.

- Нэгдүгээрт, ан агнах зөвшөөрлийн бичиг нь тав хүртэлх хоногийн хугацаатай байдаг бөгөөд хэрэв тухайн хугацаанд ан хийж чадаагүй бол дахин зөвшөөрөл авах шаардлага үүсдэг тул төлбөр төлж зөвшөөрөл авах сонирхолгүй байдаг. Мөн чоно агнах зөвшөөрлийн төлбөр өндөр тул зөвшөөрөл авах боломж малчдын хувьд хязгаарлагдмал байна.
- Хоёрдугаарт, хуульд заасны дагуу ан агнах зөвшөөрөл авахад шаардлагатай олон баримт бичиг бүрдүүлэх нь малчин иргэдийн хувьд хүндрэлтэй байдаг бөгөөд тухайлбал, ангийн буу өмчлөх, эзэмших зөвшөөрөл авахад хүндрэлтэй байдаг.
- Гуравдугаарт, малчин иргэд зөвшөөрөлгүй чоно агнавал торгууль өндөр, чоно хүн рүү болон мал руу дайрвал заавал зөвшөөрөл авч байж буудахгүй бол зөвшөөрөлгүй ан агнасан хэргээр торгууль оногдуулах заалттай учир иргэд чоно агнахгүй байгаагаас болж чоно элбэгшиж, хүнээс айхгүй түвшинд хүрсэн. Мөн чоно ихэссэнээс бодын төл авч чадахаа байхад хүрч байгаа нь малчдын амжиргаанд нөлөөлж байгаа тул үүнийг амьдралд тохиромжтой байдлаар зохицуулж өгөхийг хүсч байна.

Малчид өмнө нь чоно ихэссэн тохиолдолд нийлж чоно агнадаг байсан буюу чоно агнасан хүнийг нэг хониор шагнадаг байсан, одоо малчин иргэд зөвшөөрөлгүй чоно агнах боломжгүй, амь насаа, мал сүргээ чононоос хэрхэн хамгаалахаа мэдэхгүй байгаа талаар мэдээлэл өгсөн буюу бодит амьдралд уг хуулийн заалтууд нийцэхгүй байгааг илэрхийлж байна.

Чоно агнахад төлбөрөөс чөлөөлөх нөхцөл, түүний хэрэгжилтийн талаар хянан үзсэн бөгөөд дараах хуулийн зохицуулалтын хүрээнд чоно агнах төлбөрөөс чөлөөлөгдөх үндэслэл болдог байна. Үүнд:

- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3-т заасан “мал сүргийг хамгаалах болон тодорхой нутаг дэвсгэрт тоо толгойг нь сийрэгжүүлэх зорилгоор чоно агнах”;
- Амьтны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-д заасан “Байгалийн тэнцлийг хангах, хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, халдварт өвчний

голомтыг эрүүлжүүлэх болон мал, гэрийн тэжээвэр амьтанд өвчин халдварлах, иргэн, хуулийн этгээдэд хохирол учруулахаас сэрэмжлэх зорилгоор зарим амьтны тоо толгойг зохицуулах арга хэмжээ авч болно" гэсэн хэсэг, заалтууд байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3-д заасан "мал сүргийг хамгаалах болон тодорхой нутаг дэвсгэрт тоо толгойг нь сийрэгжүүлэх.." нөхцөлийг тогтохдоо Амьтны тухай хуульд заасны дагуу тухайн амьтны тархац, байршил, нөөц, төрөл, зүйл, тоо толгой, сүргийн бүтэц, өөрчлөлтийг судлан тогтоож, агнуурын нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, өсгөн үржүүлэх арга хэмжээг цогц байдлаар тодорхойлж тухайн аймгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөнд тусгасан байх хуулийн зохицуулалттай.

Харин Амьтны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-д "Байгалийн тэнцлийг хангах, хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, халдварт өвчний голомтыг эрүүлжүүлэх болон мал, гэрийн тэжээвэр амьтанд өвчин халдварлах, иргэн, хуулийн этгээдэд хохирол учруулахаас сэрэмжлэх зорилгоор зарим амьтны тоо толгойг зохицуулах арга хэмжээ авч болно" гэж заасан бөгөөд өнгөрсөн хугацаанд аймгуудын мэргэжлийн байгууллагад чонотой холбоотой дээрх нөхцөл тогтоогдож бүртгэгдсэн тохиолдол байхгүй байна.

Зөвшөөрөлгүй чоно агнасан тохиолдолд Зөрчлийн тухай хууль болон Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн дагуу дараах хариуцлагыг хүлээлгэдэг. Үүнд:

- Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйлд заасны дагуу хугацаа дууссан гэрээ, зөвшөөрлөөр, эсхүл гэрээ, зөвшөөрөлгүйгээр амьтныг ашигласан, барьсан, агнасан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно;
- Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.4 дэх хэсэгт заасны дагуу амьтны аймагт учирсан хохирлыг тухайн амьтны экологи-эдийн засгийн үнэлгээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний нөхөн төлбөрийг төлүүлнэ.

Торгууль, нөхөн төлбөрийн хэмжээ: Засгийн газрын 2023 оны "Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлах тухай" 260 дугаар тогтоолын хавсралтад заасны дагуу чонон экологи-эдийн засгийн үнэлгээг 1,130,000 сая төгрөгөөр тогтоосон байна. Зөвшөөрөлгүй чоно агнасан тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйлд заасны дагуу торгууль төлөхөөс гадна Байгаль орчныг хамгаалах тухай

хуулийн 49 дүгээр зүйлийн 49.4 дэх хэсэгт заасны дагуу 2,260,000 төгрөгийн нөхөн төлбөр төлдөг.

Зөвшөөрөлгүй чоно агнасан тохиолдолд хүлээлгэх торгууль, төлбөрийн хэмжээг хууль тогтоомжоор тодорхой зохицуулсан боловч амь нас, мал сүрэгээ хамгаалах шаардлага үүсч тухайн үедээ зөвшөөрөлгүй чоно агнасан ч торгууль, төлбөр төлөхөөр зохицуулсан нь Монгол Улсын үндсэн хуульд заасан амьд явах эрх, өмчтэй байх эрхүүд зөрчигдөх хэмжээний зохицуулалт байгааг илтгэж байна. Түүнчлэн өргөн уудам нутаг дэвсгэрт нүүдлийн соёлтой амьдарч буй малчин иргэд чоно агнах нөхцөл үүсвэл зөвшөөрөл авах гэж материал бүрдүүлж байж агнахгүй бол торгууль төлөхөөр зохицуулсан нь бодит амьдралд нийцэх зохицуулалт биш байгааг илтгэж байна.

Энэхүү хуулийн төсөл нь 2 зүйлтэй бөгөөд Амьтны тухай хуулийн 25 дугаар зүйлд нэмэлт оруулахаар зохицуулсан.

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын үндсэн хуульд заасан амьд явах, өмчтэй байх эрх бүрэн хангагдах ач холбогдолтой.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

/Төсөл/

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

АМЬТНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Амьтны тухай хуулийн 25 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 25.7 дахь хэсэг нэмсүгэй.

“25.7. Амь нас, мал сүргээ хамгаалах зорилгоор чоно агнасан бол энэ хуулийн 25.1 дэх заалт хамаарахгүй.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

АМЬТНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛСАН ТАЙЛАН

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсад 1986 оны байдлаар 30 гаруй мянган чоно 18 аймгийн нутаг дэвсгэрт тархсан гэж Шинжлэх ухааны академийн Биологийн хүрээлэнгийн эрдэмтдийн гаргасан судалгаанд дурджээ. Үүнээс хойш улсын хэмжээнд чонон талаар нарийвчлан судалсан судалгаа, мэдээлэл байхгүй байна.

Амьтны тухай хууль 2012 онд батлагдсанаар бүс нутгийн амьтны зүйлийн бүрдэл, тэдгээрийн тархац, нөөцийн судалгааг хийж зэрлэг амьтны мэдээллийн санг тогтмол шинэчилсний үндсэн дээр зэрлэг амьтныг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх ан агнуурын менежментийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн.

Амьтны тухай хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу иргэн зохих төлбөр төлж, сумын Засаг даргаас олгосон эрхийн бичгийн дагуу агнуурын ховор амьтнаас бусад амьтныг өөрийн ахуйн зориулалтаар агнаж, барьж болох бөгөөд тус эрхийн бичигт иргэний овог, нэр, агнах, барих агнуурын амьтны зүйл, тоо, агнах, барих хугацаа, газар, төлбөр, хураамжийн хэмжээг нарийвчлан заадаг. Тус хуулийн 28 дугаар зүйлийн 28.3.2-т заасны дагуу чоно агнах, барих зөвшөөрлийг тав хүртэл хоногийн хугацаатай олгодог байна.

Мөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3, 17 дугаар зүйлийн 17.1.2-д тус тус заасны дагуу Засгийн газрын 2023 оны “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлах тухай” 260 дугаар тогтоолыг үндэслэн тухайн амьтны экологи-эдийн засгийн үнэлгээний 20 хувиар буюу 226,000 төгрөгөөр, зөвшөөрлийн хураамжийг 2 хувиар буюу 22,600 төгрөгөөр тус тус тооцож нэг чоно агнах зөвшөөрөл 248,600 төгрөгийн үнэлгээтэй байна.²

Улсын Их Хурлын гишүүн миний бие сонгогдсон аймаг, сум, багт ажиллах үед малчид иргэдийн хамгийн ихээр тавьж байсан саналын нэг нь чоно агнахтай холбоотой асуудал байв. Иргэд, малчид чоно агнах, түүнтэй холбоотой төлбөр, зөвшөөрлийн талаар дараах агуулга бүхий тайлбар, мэдээллийг өгсөн болно.

² Засгийн газрын 2011 оны “Үнэлгээ, төлбөр, хураамжийн хэмжээг шинэчлэн батлах тухай” 23 дугаар тогтоолын дагуу чоно агнах зөвшөөрлийн төлбөрийг тухайн амьтны экологи-эдийн засгийн үнэлгээний 20 хувиар буюу 102,000 төгрөгөөр, зөвшөөрлийн хураамжийг 2 хувиар буюу 10,200 төгрөгөөр тус тус тооцож нэг чоно агнах зөвшөөрөл 112,200 төгрөгийн үнэлгээтэй байсан.

- Нэгдүгээрт, ан агнах зөвшөөрлийн бичиг нь тав хүртэлх хоногийн хугацаатай байдаг бөгөөд хэрэв тухайн хугацаанд ан хийж чадаагүй бол дахин зөвшөөрөл авах шаардлага үүсдэг тул төлбөр төлж зөвшөөрөл авах сонирхолгүй байдаг. Мөн чоно агнах зөвшөөрлийн төлбөр өндөр тул зөвшөөрөл авах боломж малчдын хувьд хязгаарлагдмал байна.
- Хоёрдугаарт, хуульд заасны дагуу ан агнах зөвшөөрөл авахад шаардлагатай олон баримт бичиг бүрдүүлэх нь малчин иргэдийн хувьд хүндрэлтэй байдаг бөгөөд тухайлбал, ангийн буу өмчлөх, эзэмших зөвшөөрөл авахад хүндрэлтэй байдаг.
- Гуравдугаарт, малчин иргэд зөвшөөрөлгүй чоно агнавал торгууль өндөр, чоно хүн рүү болон мал руу дайрвал заавал зөвшөөрөл авч байж буудахгүй бол зөвшөөрөлгүй ан агнасан хэргээр торгууль оногдуулах заалттай учир иргэд чоно агнахгүй байгаагаас болж чоно элбэгшиж, хүнээс айхгүй түвшинд хүрсэн. Мөн чоно ихэссэнээс бодын төл авч чадахаа байхад хүрч байгаа нь малчдын амжиргаанд нөлөөлж байгаа тул үүнийг амьдралд тохиромжтой байдлаар зохицуулж өгөхийг хүсч байна.

Малчид өмнө нь чоно ихэссэн тохиолдолд нийлж чоно агнадаг байсан буюу чоно агнасан хүнийг нэг хониор шагнадаг байсан, одоо малчин иргэд зөвшөөрөлгүй чоно агнах боломжгүй, амь насаа, мал сүргээ чононоос хэрхэн хамгаалахаа мэдэхгүй байгаа талаар мэдээлэл өгсөн буюу бодит амьдралд уг хуулийн заалтууд нийцэхгүй байгааг илэрхийлж байна.

Чоно агнахад төлбөрөөс чөлөөлөх нөхцөл, түүний хэрэгжилтийн талаар хянан үзсэн бөгөөд дараах хуулийн зохицуулалтын хүрээнд чоно агнах төлбөрөөс чөлөөлөгдөх үндэслэл болдог байна. Үүнд:

- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3-т заасан “мал сүргийг хамгаалах болон тодорхой нутаг дэвсгэрт тоо толгойг нь сийрэгжүүлэх зорилгоор чоно агнах”;
- Амьтны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-д заасан “Байгалийн тэнцлийг хангах, хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, халдварт өвчний голомтыг эрүүлжүүлэх болон мал, гэрийн тэжээвэр амьтанд өвчин халдварлах, иргэн, хуулийн этгээдэд хохирол учруулахаас сэрэмжлэх зорилгоор зарим амьтны тоо толгойг зохицуулах арга хэмжээ авч болно” гэсэн хэсэг, заалтууд байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3-д заасан “мал сүргийг хамгаалах болон тодорхой нутаг дэвсгэрт тоо толгойг нь

сийрэгжүүлэх.” нөхцөлийг тогтохдоо Амьтны тухай хуульд заасны дагуу тухайн амьтны тархац, байршил, нөөц, төрөл, зүйл, тоо толгой, сүргийн бүтэц, өөрчлөлтийг судлан тогтоож, агнуурын нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, өсгөн үржүүлэх арга хэмжээг цогц байдлаар тодорхойлж тухайн аймгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөнд тусгасан байх хуулийн зохицуулалттай.

Харин Амьтны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-д “Байгалийн тэнцлийг хангах, хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, халдварт өвчний голомтыг эрүүлжүүлэх болон мал, гэрийн тэжээвэр амьтанд өвчин халдварлах, иргэн, хуулийн этгээдэд хохирол учруулахаас сэрэмжлэх зорилгоор зарим амьтны тоо толгойг зохицуулах арга хэмжээ авч болно” гэж заасан бөгөөд өнгөрсөн хугацаанд аймгуудын мэргэжлийн байгууллагад чонотой холбоотой дээрх нөхцөл тогтоогдож бүртгэгдсэн тохиолдол байхгүй байна.

Иймд дээрх хууль зүйн болон практик шаардлагын үүднээс Амьтны тухай хуульд нэмэлт оруулах замаар асуудлыг шийдвэрлэх боломжтой гэж хууль санаачлагчийн зүгээс хуулийн төслийг боловсрууллаа.

НЭГ.АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар миний бие санаачлан боловсруулсан Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт заасны дагуу судалсан болно.

Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль болон олон улсын гэрээнд харшлаагүй нийцэж байна.

ХОЁР.АСУУДЛЫГ ҮҮСГЭЖ БУЙ УЧИР ШАЛТГААН

Амьтны тухай хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу иргэн зохих төлбөр төлж, сумын Засаг даргаас олгосон эрхийн бичгийн дагуу агнуурын ховор амьтнаас бусад амьтныг өөрийн ахуйн зориулалтаар агнаж, барьж болох бөгөөд тус эрхийн бичигт иргэний овог, нэр, агнах, барих агнуурын амьтны зүйл, тоо, агнах, барих хугацаа, газар, төлбөр, хураамжийн хэмжээг нарийвчлан заадаг. Тус хуулийн 28 дугаар зүйлийн 28.3.2-т заасны дагуу чоно агнах, барих зөвшөөрлийг тав хүртэл хоногийн хугацаатай олгодог байна.

Мөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3, 17 дугаар зүйлийн 17.1.2-д тус тус заасны дагуу Засгийн газрын 2023 оны “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлах тухай” 260 дугаар тогтоолыг үндэслэн тухайн амьтны экологи-эдийн засгийн үнэлгээний 20 хувиар буюу 226,000 төгрөгөөр, зөвшөөрлийн хураамжийг 2 хувиар буюу 22,600

төгрөгөөр тус тус тооцож нэг чоно агнах зөвшөөрөл 248,600 төгрөгийн үнэлгээтэй байна.³

Улсын Их Хурлын гишүүн миний бие сонгогдсон аймаг, сум, багт ажиллах үед малчид иргэдийн хамгийн ихээр тавьж байсан саналын нэг нь чоно агнахтай холбоотой асуудал байв. Иргэд, малчид чоно агнах, түүнтэй холбоотой төлбөр, зөвшөөрлийн талаар дараах агуулга бүхий тайлбар, мэдээллийг өгсөн болно.

- Нэгдүгээрт, ан агнах зөвшөөрлийн бичиг нь тав хүртэлх хоногийн хугацаатай байдаг бөгөөд хэрэв тухайн хугацаанд ан хийж чадаагүй бол дахин зөвшөөрөл авах шаардлага үүсдэг тул төлбөр төлж зөвшөөрөл авах сонирхолгүй байдаг. Мөн чоно агнах зөвшөөрлийн төлбөр өндөр тул зөвшөөрөл авах боломж малчдын хувьд хязгаарлагдмал байна.
- Хоёрдугаарт, хуульд заасны дагуу ан агнах зөвшөөрөл авахад шаардлагатай олон баримт бичиг бүрдүүлэх нь малчин иргэдийн хувьд хүндрэлтэй байдаг бөгөөд тухайлбал, ангийн буу өмчлөх, эзэмших зөвшөөрөл авахад хүндрэлтэй байдаг.
- Гуравдугаарт, малчин иргэд зөвшөөрөлгүй чоно агнавал торгууль өндөр, чоно хүн рүү болон мал руу дайрвал заавал зөвшөөрөл авч байж буудахгүй бол зөвшөөрөлгүй ан агнасан хэргээр торгууль оногдуулах заалттай учир иргэд чоно агнахгүй байгаагаас болж чоно элбэгшиж, хүнээс айхгүй түвшинд хүрсэн.

Мөн чоно ихэссэнээс бодын төл авч чадахаа байхад хүрч байгаа нь малчдын амжиргаанд нөлөөлж байгаа тул үүнийг амьдралд тохиромжтой байдлаар зохицуулж өгөхийг хүсч байна.

Малчид өмнө нь чоно ихэссэн тохиолдолд нийлж чоно агнадаг байсан буюу чоно агнасан хүнийг нэг хониор шагнадаг байсан, одоо малчин иргэд зөвшөөрөлгүй чоно агнах боломжгүй, амь насаа, мал сүргээ чононоос хэрхэн хамгаалахаа мэдэхгүй байгаа талаар мэдээлэл өгсөн буюу бодит амьдралд уг хуулийн заалтууд нийцэхгүй байгааг илэрхийлж байна.

Иймд энэхүү хууль нь цаг үеэ олсон, дээрх харилцааг зохицуулахад чиглэсэн чухал шаардлагатай хуулийн төсөл болсон байна.

³ Засгийн газрын 2011 оны “Үнэлгээ, төлбөр, хураамжийн хэмжээг шинэчлэн батлах тухай” 23 дугаар тогтоолын дагуу чоно агнах зөвшөөрлийн төлбөрийг тухайн амьтны экологи-эдийн засгийн үнэлгээний 20 хувиар буюу 102,000 төгрөгөөр, зөвшөөрлийн хураамжийг 2 хувиар буюу 10,200 төгрөгөөр тус тус тооцож нэг чоно агнах зөвшөөрөл 112,200 төгрөгийн үнэлгээтэй байсан.

ГУРАВ.АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Зөвшөөрөлгүй чоно агнасан тохиолдолд Зөрчлийн тухай хууль болон Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн дагуу дараах хариуцлагыг хүлээлгэдэг. Үүнд:

- Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйлд заасны дагуу хугацаа дууссан гэрээ, зөвшөөрлөөр, эсхүл гэрээ, зөвшөөрөлгүйгээр амьтныг ашигласан, барьсан, агнасан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно;
- Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.4 дэх хэсэгт заасны дагуу амьтны аймагт учирсан хохирлыг тухайн амьтны экологи–эдийн засгийн үнэлгээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний нөхөн төлбөрийг төлүүлнэ.

Торгууль, нөхөн төлбөрийн хэмжээ: Засгийн газрын 2023 оны “Амьтны экологиэдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлах тухай” 260 дугаар тогтоолын хавсралтад заасны дагуу чонон экологи-эдийн засгийн үнэлгээг 1,130,000 сая төгрөгөөр тогтоосон байна. Зөвшөөрөлгүй чоно агнасан тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйлд заасны дагуу торгууль төлөхөөс гадна Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.4 дэх хэсэгт заасны дагуу 2,260,000 төгрөгийн нөхөн төлбөр төлдөг.

Зөвшөөрөлгүй чоно агнасан тохиолдолд хүлээлгэх торгууль, төлбөрийн хэмжээг хууль тогтоомжоор тодорхой зохицуулсан боловч амь нас, мал сүрэгээ хамгаалах шаардлага үүсч тухайн үедээ зөвшөөрөлгүй чоно агнасан ч торгууль, төлбөр төлөхөөр зохицуулсан нь Монгол Улсын үндсэн хуульд заасан амьд явах эрх, өмчтэй байх эрхүүд зөрчигдөх хэмжээний зохицуулалт байгааг илтгэж байна. Түүнчлэн өргөн уудам нутаг дэвсгэрт нүүдлийн соёлтой амьдарч буй малчин иргэд чоно агнах нөхцөл үүсвэл зөвшөөрөл авах гэж материал бүрдүүлж байж агнахгүй бол тогууль төлөхөөр зохицуулсан нь бодит амьдрал нийцэх зохицуулалт биш байгааг илтгэж байна.

Иймд дээрх хууль зүйн болон практик шаардлагын үүднээс Амьтны тухай хуульд нэмэлт оруулах замаар асуудлыг шийдвэрлэх боломжтой гэж хууль санаачлагчийн зүгээс хуулийн төслийг боловсрууллаа.

ДӨРӨВ.АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын 5.1-т заасан зохицуулалтын хувилбарын дагуу асуудлыг зохицуулах хувилбарыг тогтоож, эерэг болон сөрөг талыг нь харьцуулан судалж дараах дүгнэлтийг гаргалаа:

	Хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа
1	Амь нас, мал сүрэгээ хамгаалах эрх хэрэгжих байдал	Зорилгодоо хүрэх бүрэн боломжтой	Уг эрх бүрэн хэрэгжих сайн шийдэл болно.
2	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Зорилгодоо хүрэх бүрэн боломжтой	Илүү зардал гарахгүй

ТАВ.ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Аргачлалын 6-д заасны дагуу сонгосон хувилбарын үр нөлөөг ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

Жич: Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг хүснэгт 1, 2, 3, 4-өөс үзнэ үү.

ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт	Тайлбар
1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх	1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх		
